



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/14

Арвайхээр сум

**Худалдан авах ажиллагааны газрын
дүрмийг батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 312 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоолын 4.26 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг “Худалдан авах ажиллагааны газар”-ын дүрмийг хавсралтаар баталсугай.

2.Тус дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газар (Ц.Идэрсайхан)-т үүрэг болгосугай.


ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

3224 11 0029

Аймгийн Засаг даргын 2024 оны ... дүгээр
сарын ... -ны өдрийн ... дугаар
захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газар /цаашид “газар” гэх/ нь Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг эрхлэх чиг үүрэг бүхий аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг мөн.

1.2. Газрын бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг энэ дүрмээр зохицуулна.

1.3. Газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Захиргааны ерөнхий хууль, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Иргэний хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Авилгын эсрэг хууль, Гамшгаас хамгаалах хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль эрх зүйн актууд, Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын гаргасан шийдвэрүүд болон холбогдох хууль эрх зүйн актуудыг мөрдлөг болгоно.

1.4. Газар нь улсын бүртгэлд бүртгүүлж, хэвлэмэл хуудас, тамга тэмдэг хэрэглэнэ.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Газрын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг аймгийн Засаг дарга батална.

2.2. Газрын даргыг Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай аймгийн Засаг дарга зөвшилцөн томилно.

2.3. Албан хаагчдыг Газрын даргын шийдвэрээр томилж, чөлөөлнө.

2.4. Газар нь хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын дотоод журмыг батлан мөрдүүлнэ.

2.5. Газрын даргыг эзгүйд хууль журмын хүрээнд шилжүүлсэн бүрэн эрхийг газрын ахлах мэргэжилтэн орлоно.

2.6. Газар нь улс, орон нутгийн төсвөөр зохион байгуулагдах худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах ажлыг аймгийн Засаг даргын өмнө бүрэн хариуцна.

2.7. Газар нь үйл ажиллагааны болон худалдан авах ажиллагааны тайланг хуулийн хугацаанд Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулна.

2.8. Аймгийн хэмжээнд худалдан авах ажиллагааны талаарх баримтлах бодлого чиглэлийг боловсруулж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулна.

2.9. Тухайн жилийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, сумд, төсөвт

байгууллагуудын зохион байгуулж буй худалдан авах ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил аргагүйн зөвлөгөө өгнө.

2.10. Ажлын байр, тоног төхөөрөмж, албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах асуудлыг Төрийн албаны тухай хууль, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэнэ.

Гурав. Газрын үндсэн чиг үүрэг

3.1. Газар нь аймгийн Засаг даргаар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж ажиллах ба төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах гэсэн үндсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулна. Үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохицуулах, ил тод нээлттэй болгох, үйл ажиллагаанд хяналт тавин, хэрэгжүүлэхэд оршино.

3.2. Газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.2.1. Улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, төсөл хөтөлбөр, төсвийн хүрээний худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих

3.2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох тогтоол, шийдвэрийг төрийн байгууллагуудад суртчилан таниулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах

3.2.3. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа албан хаагчид, хөндлөнгийн төлөөллүүдийг мэргэшүүлэх, давтан сургах

3.2.4. Төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулж, цахим системийн шинэчлэлийг нэвтрүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

3.2.5. Төрийн худалдан авах ажиллагаанд дотоодын давуу эрх тооцох замаар худалдан авалтыг дэмжиж, тендер шалгаруулалтын үйл ажиллагаанд дэвшилтэт технологи ашиглах

3.2.6. Харьяа төсвийн байгууллагуудын төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааны өөрчлөлтийг хууль, журамд нийцүүлэн баталгаажуулж, хяналт тавих

3.2.7. Тухайн жилд зохион байгуулагдсан төсөл арга хэмжээний хэрэгжилтийг тухай бүр цахим системд оруулж, батлуулах.

3.2.8. Шууд худалдан авахаар төлөвлөгдсөн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний үнийн дүнг цахим системд байршуулах, тэдгээрт хяналт тавих

3.2.9. Худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол, саналд дүн шинжилгээ хийх, санал, гомдлын мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлэх, захиалагчийн шийдвэрт гарч буй гомдлын тоог бууруулах

3.2.10. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35, 36 дугаар зүйлд заасан үндэслэлээр гэрээ шууд байгуулсан бол материалыг ажлын 10 өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.

3.2.11. Албан хаагчид болон үнэлгээний хороонд ажиллаж буй төрийн албан хаагчид, хөндлөнгийн төлөөллүүдэд авилга, ашиг сонирхлын зөрчлийн хор уршгийг тайлбарлан таниулж, ашиг сонирхлын зөрчил гаргуулахгүй байх талаарх сургалтыг үе шаттай зохион байгуулах.

3.2.12. Үнэлгээний хорооны гишүүнээр томилогдсон гишүүдээс Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр

хавсралтаар батлагдсан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг гаргуулан авч цахим системд бүртгэх, нэгдсэн мэдээллийн сан бий болгох.

3.2.13.Худалдан авах ажиллагааны төлөвлөлтөөс гүйцэтгэлийн үе шатуудыг Uvurkhangai.mn болон shilendans.gov.mn цахим системд тогтмол мэдээллэх.

Дөрөв. Бусад зүйл

4.1.Энэхүү дүрэмд аймгийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

4.2.Дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр улсын бүртгэлд бүртгүүлнэ.

-оОо-